



САНГИЙН ЯАМ

ЭРЧИМ ХҮЧ
 ГААЛИЙН ШИНЭЧЛЭЛ
 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ
 ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
 ХҮРЭЭЛЭН БУИ ОРЧИН
 ОРОН НУТАГ
 ЗАРЛАГЫН РЕФОРМ
 ЦАЛИН ЦАХИМ
 ТӨСВИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ
 САХИЛГА БАТ
 ТЭТГЭВЭР ҮР АШИГТАЙ
 ТУСГАЙ САН БОЛОВСРОЛ
 ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ
 ХӨДӨӨ АЖ АХУЙ
 МЭРГЭЖЛИЙН ГАЗРЫН ДЭД ЦАХИМ БҮТЭЦ БҮРТГЭЛ
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
 ЭРҮҮЛ МЭНД ЭКОЛОГИЙН ЦАГДАА
 ТАТААС
 ХӨГЖЛИЙН ТҮНШЛЭЛ
 УРАМШУУЛАЛ
 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН



ИРГЭДИЙН ТӨСӨВ 2020
 МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ



САНГИЙН ЯАМ



Монгол Улсын Сангийн яамны санаачилгаар, Европын холбооны буцалтгүй тусламжийн хүрээнд Дэлхийн банкны хэрэгжүүлж буй Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх төслийн санхүүжилтээр энэхүү “Иргэдийн төсөв-2020” товхимлыг бэлтгэн гаргав.

Уг товхимлыг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд **“Иргэдийн төсөв-2020, Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл”, Сангийн яам** хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу.

Санал хүсэлт болон агуулгатай холбоотой лавлах зүйл байвал Сангийн яамны tusuv@mof.gov.mn цахим шууданд ирүүлнэ үү.

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын төсвийн тухай мэдээллийг иргэдэд илтгэдэг, нээлттэй, ойлгомжтой байдлаар хүргэхээр Сангийн яамнаас “Иргэдийн төсөв” эмхэтгэлийг **гурван дах** жилдээ Та бүхэнд бэлтгэн хүргэж байна.

Төсөв нь улсын эдийн засгийн чадавх ямар түвшинд байгаа, төсвийн жилд иргэдийн нийгмийн үйлчилгээ, бодит орлого яаж өсөн нэмэгдэх, улс орны хөгжилд ямар ахиц өөрчлөлт гарах зэрэг шалгуур үзүүлэлтүүдийн цогц илэрхийлэл билээ.

Энэхүү эмхэтгэлд 2020 онд Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын шинэчлэл, иргэдэд хүргэх нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг зураг, текст, инфографик ашиглан Та бүхэнд толилуулж байна.

2020 оноос татварын шинэчилсэн хуулийг даган мөрдөж, гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлэхээс гадна нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, төсвийн урсгал зардлын реформыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Дээрх бодлогын арга хэмжээний үр дүнд Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 11.8 их наяд төгрөг, нийт зарлагыг 13.9 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцлийг -2.1 их наяд төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий -5.1 хувьтай тэнцэхээр байна.

Энэхүү эмхэтгэлээс 2020 оны төсвийн бодлого, орлого, зарлага, хөрөнгө оруулалт, Засгийн газрын гадаад зээл, тусламж зэргийн талаар мэдээлэл авах боломжтойгоос гадна төсөв боловсруулах үйл явц иргэдийн оролцоо мөн иргэдэд чиглэсэн үйлчилгээг хаанаас авах талаарх мэдээллүүдийг багтааснаараа өмнөх жилүүдийн хэвлэлээс онцлог боллоо.

Иргэн Та “Иргэдийн төсөв-2020” эмхэтгэлийг хэвлэмлээс гадна цахим хэлбэрээр Сангийн яамны цахим хуудас www.mof.gov.mn, www.iltod.gov.mn болон олон нийтийн мэдээллийн сүлжээнээс үзэх боломжтой.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР

ИРГЭДИЙН ТӨСӨВ-2020

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

АГУУЛГА

06

ТӨСВИЙН ТУХАЙ

Төсвийн бүрэлдэхүүн
Төсвийн бодлого
Нэгдсэн төсвийн үзүүлэлт

10

ТӨСВИЙН ОРЛОГО

2020 оны төсвийн нийт орлого
Төсвийн орлогыг нэмэгдүүлж буй хүчин зүйлс
Татварын шинэчлэл
Гаалийн шинэчлэл
Газрын бүртгэл, төлбөрийн шинэчлэл
Цахим төлбөрийн баримтын мэдээллийн системийн шинэчлэл

18

ТӨСВИЙН ЗАРЛАГА

Нэгдсэн төсвийн зарлага эдийн засгийн ангиллаар
Улсын төсвийн зарлага Ерөнхийлөн захирагчаар
Засгийн газрын тусгай сангууд
Төсвийн зарлага салбараар
Боловсрол
Эрүүл мэнд
Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал
Нийгмийн хамгаалал
Нийгмийн халамжийн сан
Нийгмийн даатгалын сан
Аюулгүй байдал, нийгмийн хэв журам
Эдийн засгийн үйл ажиллагаа
Хөдөө аж ахуй
Төрийн нийтлэг үйл ажиллагаа
Соёл урлаг, спорт, аялал жуулчлал
Хөрөнгө оруулалт

39

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Засгийн газрын өр
Засгийн газрын гадаад зээл, тусламж

44

НИЙГМИЙН БҮЛЭГТ ЧИГЛЭСЭН ТӨСӨВ

Хүүхдийг төрөөс хэрхэн анхаардаг вэ?
Ахмад настанд чиглэсэн төсөв
Төрийн албан хаагч, иргэдийн нийгмийн баталгаа
Малчдад чиглэсэн бодлогууд
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн бодлогууд
Эхчүүдэд чиглэсэн бодлогууд

53


ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Улс, орон нутгийн төсвийн харилцаа
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
Улаанбаатар хот, 21 аймгийн төсөв, хөрөнгө оруулалт

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ


▶ АНУ	Америкийн Нэгдсэн Улс
▶ БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
▶ БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
▶ БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
▶ БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
▶ БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
▶ БХЯ	Батлан хамгаалах яам
▶ ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
▶ ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
▶ ЗГ	Засгийн газар
▶ ЗДТГ	Засаг даргын тамгын газар
▶ ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
▶ НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
▶ НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
▶ НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
▶ ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
▶ ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
▶ УИХ	Улсын Их Хурал
▶ ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
▶ ХААХОУС	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
▶ ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
▶ ХЭДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
▶ ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
▶ ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
▶ ШУ	Шинжлэх ухаан
▶ ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
▶ ЭМЯ	Эрүүл мэндийн яам

ТӨСВИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Монгол Улсын нэгдсэн төсөв нь Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын төсөв, Орон нутгийн төсвөөс бүрддэг. Улсын төсвийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх болон тайлагнах гэсэн үе шатууд нь 3 жил дамнан тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм.

■ Төсөв боловсруулах, батлах цаглабар, иргэдийн оролцоо



Өргөн барьсан төсвийн төсөл, батлагдсан төсвийн “Иргэдийн төсөв” эмхэтгэлээс гадна улирлын гүйцэтгэлийн иргэдийн төсөв номыг бэлтгэн хүргэж байгааг доорх холбоосоор авна уу.


1-р улирлын гүйцэтгэл



Хагас жилийн гүйцэтгэл



3-р улирлын гүйцэтгэл



ТӨСВИЙН БОДЛОГО

Засгийн Газраас 2020 оны төсвийг боловсруулахдаа дараах бодлогыг баримталсан.



- ✓ Цахим
- ✓ Ил тод
- ✓ Үр ашигтай

ТӨСӨВ



Төсвийн сахилга батыг тууштай үргэлжлүүлэн, төсвийг эрүүлжүүлэх, алдагдлыг үе шаттай бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ



Бондуудын эргэн төлөлттэй холбоотойгоор төсвийн алдагдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хэмжээнээс сайжруулан цаашид ашигтай гаргах бодлого баримтална.

ТӨСВИЙН ОРЛОГО



Гаалийн шинэчлэл, татварын хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлж эдийн засаг, бизнесийн орчин, хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Газрын төлбөрийг бүрэн хураах чиглэлээр хууль, эрхзүйн орчныг сайжруулах, газрын бүртгэлийг цахимжуулах, ил тод болгох ажлыг хийж гүйцэтгэнэ.

ТӨСВИЙН ЗАРЛАГА



Зарлагын реформыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийгмийн ач холбогдол бүхий эдийн засгийн үр ашигтай төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ



Гадаадын зээл тусламжийг эдийн засаг, нийгэм, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр үр ашигтай зарцуулна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР



Өндөр хүүтэй гадаад үнэт цаасны төлбөрийг төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүйгээр төлж, өрийн зохистой менежментийг хэрэгжүүлнэ.


ОРОН НУТГИЙН ТӨСӨВ




Төсвийн төвлөрлийг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлийг баримтална.

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Төсвийн үр ашигт бодлого хэрэгжүүлсний үр дүнд 2020 онд манай улсын төслийн алдагдал 2 их наяд төгрөг байна. Төсвийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь жил ирэх тусам хэрхэн багасаж байгааг харцгаая.



НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДАЛ 2016-2022 ОН



Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь **-2,074.7 тэрбум** төгрөг байгаагаас гадаад зээлийн ашиглалтын **1,196.3 тэрбум** төгрөг нь эх үүсвэртэй алдагдал юм. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу төсвийн тогтворжуулалтын сангаас нийт **478.8 тэрбум** төгрөгийг төсвийн алдагдлыг нөхөхөд ашиглахаар тусгасан.


ТӨСВИЙН ОРЛОГО

АГУУЛГА

01	2020 оны төсвийн нийт орлого	11
02	Төсвийн орлогыг нэмэгдүүлж буй хүчин зүйлс	12
03	Татварын шинэчлэл	13
04	Гаалийн шинэчлэл	14
05	Газрын бүртгэл, төлбөрийн шинэчлэл	16
06	Цахим төлбөрийн баримтын мэдээллийн системийн шинэчлэл	17



2020 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО




Энэ онд бизнес, хөрөнгө оруулалтын орчныг дэмжих, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, гадаад худалдааг хөнгөвчлөх, татварын тэгш шударга ил тод байдлыг хангах зорилгоор гааль, татварын шинэчлэлийг хэрэгжүүлэх бөгөөд газрын бүртгэлийг цахимжуулж, газрын төлбөр хураалтыг сайжруулна. Ингэснээр төсвийн орлого 2019 оны батлагдсан дүнгээс **1.8 их наяд** төгрөг буюу **16.6 хувиар** нэмэгдэж, **12.9 их наяд** төгрөгт хүрнэ.

Он	Төрөл	Хэмжээ (тэрбум)
2018	Гүйц.	207.0
2019	Бат.	322.0
2020	Бат.	125.2
2018	Гүйц.	620.7
2019	Бат.	1,068.5
2020	Бат.	977.0
2018	Гүйц.	9,345.1
2019	Бат.	9,676.5
2020	Бат.	11,797.8



Төсвийн тэнцвэржүүлсэн орлого



Төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь



ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС



2020 онд төсвийн орлого 2019 оноос **1,833 тэрбум** төгрөгөөр нэмэгдэх ба уг өсөлтөд нөлөөлж буй голлох хүчин зүйлс нь:



УУЛ УУРХАЙН ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨЛӨВ




ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ

2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс татварын багц хуулийг мөрдөж эхэллээ.



Дээрх шинэчлэлийг хийснээр иргэд, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчид татварын таатай орчинд үйл ажиллагаа явуулах боломжтой болох юм. Та шинэчилсэн хуулийн бүрэн эхийг эндээс авна уу.



* Өмнөх хуульд жилийн ашиг 3 тэрбум төгрөг хүртэл 4 тайлан, 10% татвар, 3 тэрбум төгрөгөөс дээш бол 4 тайлан, 25% татвар төлөх зохицуулалттай байсан.

Анх удаа орон сууц худалдан авахад үзүүлэх татварын хөнгөлөлт 2 дахин нэмэгдэж 6 сая төгрөг болсон.	Ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү хоорондын зөрүүгээр татварыг хөнгөлнө.	Алслагдсан аймагт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжийн татварыг 50-90% хөнгөлнө.	Хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох татварыг 50 хувиар хөнгөлнө.
---	---	---	---

ГААЛИЙН ШИНЭЧЛЭЛ



Гаалийн шинэчлэлийн бүтээн байгуулалт хийж, зарим боомтуудыг олон улсын жишигт нийцүүлснээр гадаад худалдааны эргэлт нэмэгдэж, хилээр нэвтэрч буй бараа, бүтээгдэхүүнд тавих хяналт сайжирч, ашигт малтмалын экспортоос татвараа бүрэн хураана.

1 Өндөр хүчин чадлын РЕНТГЕН болон ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ нэвтрүүлнэ.

1. Эрдэс бүтээгдэхүүний чанар, агуулга, тоо хэмжээг тодорхойлно.
2. Газрын тосны бүтээгдэхүүний чанар, агуулга, тоо хэмжээг тодорхойлно.
3. Хууль бус, чанаргүй бараа, бүтээгдэхүүнийг илрүүлж хилээр нэвтрүүлэхгүй.

2 Экспортын бүтээгдэхүүн гарч байгаа хилийн боомтуудад олон улсын стандарт шаардлагад нийцсэн тоноглол, тоног төхөөрөмж бүхий уул уурхай ЭРДСИЙН ТӨРӨЛЖСӨН ЛАБОРАТОРИЙГ байгуулж татвар, хураамжийг бүрэн ногдуулж, хураадаг болно.

3 Гаалийн ерөнхий газрын дэргэд Шуурхай хяналт, удирдлагын төв байгуулан гаалийн нэгж, цэг бүрийг автомат ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМД хамруулна.



Гаалийн шинэчлэлийн хүрээнд хийгдэх ажлууд



4 Радио давтамжит долгионоор тээврийн хэрэгслийг бүртгэх "УХААЛАГ ГАРЦ" ХЯНАЛТЫН СИСТЕМИЙГ нэвтрүүлнэ.

5

ГОЛЛОХ БООМТУУДЫГ олон улсын түвшинд нийцүүлэн цогцоор нь шинэчилнэ



Замын-Үүд боомт

Зам, талбайн хэмжээ **8** дахин

Зорчигчдын тоо **4** дахин

Ачаа тээврийн хэрэгслийн тоо **3** дахин

Суудлын тээврийн хэрэгслийн тоо **7** дахин



Гашуунсухайт боомт

Зам, талбайн хэмжээ **4** дахин

Экспортын хүчин чадал **4** дахин

Ачаа, зорчигч, тээврийн хэрэгслийн тоо **3** дахин



Алтанбулаг боомт

Зам, талбайн хэмжээ **2** дахин

Зорчигчдын тоо **3** дахин


Ачаа, суудлын тээврийн хэрэгслийн тоо **4** дахин



ГАЗРЫН БҮРТГЭЛ, ТӨЛБӨРИЙН ШИНЭЧЛЭЛ



Уг шинэчлэлийг хэрэгжүүлснээр газрыг бүрэн бүртгэж, мэдээлэл ил тод болон, иргэд бид газрын төлбөрөө богино хугацаанд хялбар төлөх бололцоотой болно. Газрын удирдлагын мэдээллийн сангийн олон нийтэд нээлттэй мэдээллийг эндээс авна уу.



ГАЗРЫН
ТӨЛБӨРИЙГ
БҮРЭН
ХУРААДАГ
БОЛНО.



Газрын төлбөрийн орлогын **40 хувийг** тухайн сум, дүүрэгт хуваарилна.



Газрын бүртгэлийг **цахимжуулж, ил тод** болгоно.



Газрын төлбөрийн хэмжээг засаг даргатай байгуулсан гэрээгээр тогтоодог байсныг өөрчилж **хууль тогтоомжийн дагуу ногдуулна.**



Газрын цахим бүртгэлийг татварын мэдээллийн **системтэй холбоно.**



Газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийг **цахимжуулна.**



ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛ



Би гадаад паспорт захиалгын төлбөрөө төлөхөөр явлаа. Удах байх шүү.


Хүүе, бидний өдөр бүр ашигладаг **EBARIMT** аппликейшнд “Төрийн үйлчилгээ” цэс нэмэгдсэн шүү дээ. Банк орж цаг алдахгүйгээр шууд л гар утсаараа олон төрлийн төрийн үйлчилгээний хураамжийг интернэт банк ашиглан төлөх боломжтой болсон. Төрийн үйлчилгээ бидэнд улам ойртож байна даа. Алив утсаа, би чамд заагаад өгье.




Ибаримт аппликейшнд өөрийн бүртгэлээр нээвтрэн үндсэн цэсийг сонгоно.




Төрийн үйлчилгээ цэсийг сонгоно.




Үйлчилгээ авах харьяа байгууллагыг сонгоно.




Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ



Үйлчилгээний төрлийг сонгоно.



Бүрдүүлэх материалтай танилцан ТӨЛӨХ товчийг дарна.



Харилцагч банкны аппликейшныг сонгож төлбөрөө төлнө.




Төлсөн төлбөрийн баримтаа төрийн үйлчилгээний цэсээс харах боломжтой. Төлбөр төлсний дараа төрийн үйлчилгээний ажилтанд регистрийн дугаараар шалгуулж, үйлчилгээгээ авна. Сугалааны дугаар бүхий төлбөрийн баримт цахимаар ибаримт системд бүртгэгдэнэ.

ТӨСВИЙН ЗАРЛАГА, САЛБАРЫН ТӨСӨВ

АГУУЛГА

01	Нэгдсэн төсвийн зарлага эдийн засгийн ангиллаар	19
02	Улсын төсвийн зарлага Ерөнхийлөн захирагчаар	20
03	Засгийн газрын тусгай сангууд	21
04	Төсвийн зарлага салбараар	22
05	Боловсрол	24
06	Эрүүл мэнд	26
07	Хүрээлэн буй орчин байгаль хамгаалал	28
08	Нийгмийн хамгаалал	20
09	Нийгмийн халамжийн сан	31
10	Нийгмийн даатгалын сан	32
11	Аюулгүй байдал, нийгмийн хэв журам	33
12	Эдийн засгийн үйл ажиллагаа	34
13	Хөдөө аж ахуй	35
14	Төрийн нийтлэг үйл ажиллагаа	36
15	Соёл урлаг, спорт, аялал жуулчлал	37
16	Хөрөнгө оруулалт	38



НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР

Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх цэвэр зээлээс бүрддэг. 2020 оны нийт зарлага 2019 оны батлагдсан дүнгээс **2,283.5** тэрбум төгрөг буюу **19.7%**-аар өснө. Урсгал зардлын өсөлт нь цалин, тэтгэвэр, тэтгэмж, шилжүүлгийн зардлыг нэмэгдүүлэх бодлоготой холбоотой.



2020 оны төсвийн зарлагын тооцооллод баримталсан зарчмууд

НИЙТ ЗАРЛАГА
(ТЭРБУМ ТӨГРӨГ) **13,872.6** ▲ 19.7%
2019 ОНООС

Урсгал зардал	Эргэж төлөгдөх цэвэр зээл	Хөрөнгийн зардал
10,019.4 ▲ 21.9% 2019 оноос	47.1 ▼ 63.2% 2019 оноос	3,806.1 ▲ 17.3% 2019 оноос
Цалин хөлс 2,628.0 ▲ 18.6%	Дотоод зээл -186.7 ▼ 2,728.1%	Барилга байгууламж 2,512.7 ▲ 14.1%
Бараа үйлчилгээ 2,157.5 ▲ 24.5%	Гадаад зээл 233.9 ▲ 93.3%	Их засвар 157.6 ▲ 0.4%
Зээлийн хүүгийн төлбөр 959.8 ▲ 10.9%		Тоног төхөөрөмж 402.9 ▲ 37.9%
Татаас 374.7 ▲ 48.9%		Бусад хөрөнгө 710.6 ▲ 24.4%
Урсгал шилжүүлэг 3,899.3 ▲ 23.7%		Стратегийн нөөц хөрөнгө 22.3 ▲ 6.9%

ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Нийгмийн хөгжлийг дэмжих зорилгоор төсвөөс хөнгөлөлттэй олгодог зээл

Барилга барих, тоног төхөөрөмж авах, их засвар хийх, стратегийн барааг улсын нөөцөд байршуулах гэх мэт зардлууд

Төсвийн байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардал

Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулж нэмэгдүүлсэн.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зардлыг төсөвт суулгасан.

Шинээр батлагдсан хууль тогтоомж болон шинэ хөрөнгө оруулалтай холбоотой нэмэгдэх зардлыг тусгасан.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын тээвэр шатахуун, түлш халаалтын зардлыг индексжүүлэн нэмэгдүүлсэн.

УИХ, орон нутгийн ээлжит сонгууль, хүн ам, орон сууцны тооллого, 2020 оны Токиогийн олимпод оролцох зэрэг нэг удаагийн шинж чанартай арга хэмжээний зардлыг тусгасан.

УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР



/Тэрбум төгрөг/

Сангийн сайд	1,593.9	175.1	1,346.6	-223.7	2,891.9
БСШУС-ын сайд	1,510.7	662.4		49.8	2,223.0
ХНХ-ын сайд	1,522.1			25.5	1,547.6
Эрүүл мэндийн сайд	830.8			133.8	964.6
ХЗДХ-ын сайд	574.9		51.0	-20.6	605.3
Монгол Улсын Ерөнхий сайд	114.0			356.4	470.4
Зам, тээврийн хөгжлийн сайд	12.4			363.0	375.4
Батлан хамгаалахын сайд	283.2			11.1	294.3
Барилга, хот байгуулалтын сайд	25.7		251.0	5.0	281.7
ХХААХҮ-ийн сайд	164.4		29.4	2.8	196.6
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	145.1			31.2	176.2
Монгол Улсын Шадар сайд	156.9			18.0	174.9
Эрчим хүчний сайд	27.5			72.6	100.1
Гадаад харилцааны сайд	90.8			2.6	93.4
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	38.5			32.5	71.0
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	56.3				56.3
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	54.5				54.5
Улсын ерөнхий прокурор	36.0			11.7	47.8
УИХ-ын дарга	44.3			2.6	46.9
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	14.1			28.8	42.9
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	38.1				38.1
Авлигатай тэмцэх газрын дарга	26.0			1.1	27.1
Монгол Улсын Ерөнхий аудитор	22.1			1.0	23.1
Үндэсний статистикийн хорооны дарга	15.4			0.7	16.0
Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	4.7			4.5	9.2
Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	6.4				6.4
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	4.8				4.8
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	4.8				4.8
Төрийн албаны зөвлөлийн дарга	3.6				3.6
Үндсэн хуулийн цэцийн дарга	2.3	0.6			2.9
Хүний эрхийн үндэсний комиссын дарга	1.3				1.3












Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрт холбогдох салбар, чиглэлийн хувьд төсвийг удирдах дээд удирдлага юм.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУД

Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор бий болгосон төсвийн тусгай сангуудыг Засгийн газрын тусгай сан гэдэг. Тусгай санг хуулиар байгуулж эсхүл татан буулгана.



■ Нийт санхүүжилт 2020 онд (тэрбум төгрөгөөр) ■ 2019 оноос өөрчлөлт


Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам 	<ul style="list-style-type: none"> Боловсролын зээлийн сан 	76.6	0.1% ▲
	<ul style="list-style-type: none"> Шинжлэх ухаан, технологийн сан 	13.5	7.1% ▲
	<ul style="list-style-type: none"> Соёл, урлагийг дэмжих сан 	2.0	
	<ul style="list-style-type: none"> Спортыг дэмжих сан 	2.0	
	<ul style="list-style-type: none"> Кино урлагийг дэмжих сан 	10.0	
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 	<ul style="list-style-type: none"> Нийгмийн даатгалын сан 	2,510.7	21.4% ▲
	<ul style="list-style-type: none"> Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан 	88.3	80.2% ▲
	<ul style="list-style-type: none"> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 	123.0	47.5% ▲
	<ul style="list-style-type: none"> Нийгмийн халамжийн сан 	756.6	8.8% ▲
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 	<ul style="list-style-type: none"> Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 	52.3	
	<ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуйг дэмжих сан 	33.0	
Эрүүл мэндийн яам 	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн даатгалын сан 	506.5	24.2% ▲
	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийг дэмжих сан 	3.0	
Гадаад харилцааны яам 	<ul style="list-style-type: none"> Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сан 	0.2	
Батлан хамгаалах яам 	<ul style="list-style-type: none"> Зэвсэгт хүчний хөгжлийн сан 	35.0	
Байгаль орчин, аялал жуулчлалын яам 	<ul style="list-style-type: none"> Байгаль орчин, уур амьсгалын сан 	2.2	15.8% ▲
Зам, тээврийн хөгжлийн яам 	<ul style="list-style-type: none"> Улсын авто замын сан 	3.0	39.5% ▲
	<ul style="list-style-type: none"> Урсгал зардал Хөрөнгийн зардал 	52.0	
Хууль зүй, дотоод хэргийн яам 	<ul style="list-style-type: none"> Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан 	0.6	
Сангийн сайд 	<ul style="list-style-type: none"> Засгийн газрын нөөц сан 	25.0	
Засгийн газрын хэрэг эрхлэх газар 	<ul style="list-style-type: none"> Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан 	3.9	85.7% ▲

ТӨСВИЙН ЗАРЛАГА САЛБАРААР

Нийт төсөв : **40.6%**
 1,334.3 тэрбум : **2019 оноос**

Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр	195.6
Эрчим хүч, уул уурхай	143.0
Зам тээвэр	435.8
Худалдаа	3.9
Харилцаа холбоо	40.5
Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй	377.2
Хөдөлмөр эрхлэлт	138.3

Эдийн засгийн үйл ажиллагаа



Нийт төсөв : **67.1%**
 409.8 тэрбум : **2019 оноос**

Биеийн тамир спорт	92.6
Соёл урлаг	308.6
Аялал жуулчлал	8.6

Соёл урлаг, спорт, аялал жуулчлал

Боловсрол

Сургуулийн өмнөх боловсрол	534.7
Ерөнхий боловсрол	955.9
Дээд боловсрол	80.5
Мэргэжлийн боловсрол	79.6
Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага, хөрөнгө оруулалт	511.5

Нийт төсөв : **14.0%**
 2,162.2 тэрбум : **2019 оноос**

Нийгмийн хэв журам, аюулгүй байдал

Зэвсэгт хүчин	294.0
Хил хамгаалах	166.3
Шүүх, прокурорын байгууллага	113.3
Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл	321.1
Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах	102.4
Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	116.7
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	10.4
Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдал, удирдлага, судалгаа шинжилгээ	45.5

Нийт төсөв : **9.6%**
 1,169.7 тэрбум : **2019 оноос**



Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал орсон.

Нийт төсөв : **44.3%**
 282.8 тэрбум : 2019 оноос

Ойжуулалт, ус, гол мөрний менежмент	13.0
Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	13.0
Агаарын бохирдлыг бууруулах	138.6
Ус цаг уур, орчны шинжилгээ	33.5
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	49.9
Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх	1.3
Хүрээлэн буй орчны бодлого, судалгаа, хөрөнгө оруулалт	33.5

Нийт төсөв : **25.6%**
 1,814.1 тэрбум : 2019 оноос

Ерөнхийлөгч, УИХ, ЗГ, Орон нутгийн удирдлага	688.3
Ерөнхий төлөвлөлт, санхүү төсвийн харилцаа	590.0
Гадаад харилцаа	93.4
Төрийн нийтлэг бусад үйл ажиллагаа	264.3
Засаг захиргааны төвшин хоорондын шилжүүлэг	178.1
Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	1,346.6
Зээлийн үйлчилгээний төлбөр	959.8

Хүрээлэн буй орчин хамгаалал

Төрийн нийтлэг үйл ажиллагаа



Эрүүл мэнд

Эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэнд	810.2
Эрүүл мэндийн бодлого, удирдлага	184.9
Эрүүл мэндийн даатгал	250.4

Нийт төсөв : **22.0%**
 1245.5 тэрбум : 2019 оноос

Нийгмийн хамгаалал


Нийгмийн даатгал	2,510.7
Нийгмийн халамж	794.5
Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	5.8
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	118.3
Нийгмийн хамгааллын хөрөнгө оруулалт	16.3

Нийт төсөв : **19.2%**
 3445.5 тэрбум : 2019 оноос

Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлээр төсвийг ангилан харвал:



БОЛОВСРОЛ



Боловсролын салбарын чанараас тухайн орны иргэдийн хөдөлмөрийн бүтээмж хамаардаг. Харин чанартай боловсрол олгох эхний алхам бол зөв зохистой санхүүжилтийг олгох явдал юм. 2020 онд манай салбарын төсөв өмнөх жилээс **14%**-аар өссөн бөгөөд хэд хэдэн онцлогтой байна:

Боловсролын салбарын төсөв

Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага, хөрөнгө оруулалт

511.5

Мэргэжлийн боловсрол

79.6

Сургуулийн өмнөх боловсрол

534.7

Ерөнхий боловсрол

955.9

Дээд боловсрол

80.5

НИЙТ
2,162.2
ТЭРБУМ ТӨГРӨГ

14.0% ▲
2019 оноос

Урсгал зардал
1,675.9

Хөрөнгийн зардал
436.4

Эргэж төлөгдөх цэвэр зээл
49.8

Онцлогууд:

- Цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хоол болон үдийн цайны зардлын тарифыг **50%** ▲
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагсад олгох тэтгэлэгийг **2 дахин** ▲
- “З ээлжгүй сургууль”, “Хүүхэд бүрт цэцэрлэг” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- Оюутны хөгжлийн зээлийг үргэлжлүүлэн олгоно.



Боловсрол, ШУ-ны бодлого, удирдлага

НИЙТ төсөв 75.1 тэрбум ▲ **21.9%** 2019 оноос



Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага

17.4
тэрбум




Насан туршийн болон албан бус боловсрол

2.1
тэрбум



Тусгай хэрэгцээт боловсрол

4.9
тэрбум



Шинжлэх ухаан, технологи

50.7
тэрбум

Нийт төсөв 80.5 тэрбум ▲ 0.6%
2019 оноос

Дээд боловсрол

- Боловсролын зээлийн сангаас санхүүжнэ.
- 33.0** Оюутны сургалтын төлбөрийн зээл
 - 14.5** Дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагсдад олгох сургалтын төлбөр
 - 12.6** Нэн ядуу, малчин, зарим суралцагсдад олгох тэтгэлэг
 - 7.3** Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагсдын сургалтын төлбөрийн зээл
 - 3.5** Гадаадад суралцагсдын зардал
 - 2.8** Багш мэргэжлээр суралцагсдад олгох сургалтын төлбөр
 - 2.4** Бусад тэтгэлгүүд
 - 5.6** Оюутны нийтийн тээврийн хөнгөлөлт



Боловсролын зээлийн сангаас оюутны сурч боловсрох нөхцөл бололцоог бий болгох, дээшлүүлэх чиглэлээр олон төрлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Оюутан та дэлгэрэнгүй мэдээллийг www.elf.mn -ээс авна уу.

Мэргэжлийн боловсрол

Нийт төсөв 159.5* тэрбум ▲ 47.4%
2019 оноос
* тэтгэлгийн зардал орсон дүн



- 75.6** тэрбум | Үйл ажиллагааны зардал
- 1.0** тэрбум | Суралцагчийн нийтийн тээврийн хөнгөлөлт
- 3.0** тэрбум | Дотуур байрны үйлчилгээ
- 80.0** тэрбум | Суралцагчдын тэтгэлэг



**Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээлэл 2019 он

Нийт төсөв 955.9 тэрбум ▲ 20.6%
2019 оноос

Ерөнхий боловсрол

Үдийн цай хөтөлбөр: 54.1 тэрбум

Хүүхдийн тоо: **352 мянга**
1-5-р ангийн сурагчид хамрагдах бөгөөд ердийн сургуулийн суралцагчид **900 төгрөг**, тусгай сургуулийн суралцагчид **2,400 төгрөг** олгоно.

Дотуур байр: 71.0 тэрбум

Хүүхдийн тоо: **35 мянга**
Хоолны зардлыг **50%** нэмэгдүүлж өдрийн **3,475 төгрөг** олгоно.



Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн 1 хүүхдэд байршил болон сургуулийн ангиллаас хамааран жилд **286,900-683,100 төгрөгийн** санхүүжилт олгодог.



Сургуулийн өмнөх боловсрол

Нийт төсөв 534.7 тэрбум ▲ 33.3%
2019 оноос


Хүүхэд харах үйлчилгээ: 3.6 тэрбум

Хөгжлийн бэрхшээлтэй болон хилийн заставт ажиллагсдын хүүхдүүдийг хамруулна.

Хүүхдийн хоол: 90.2 тэрбум

Хүүхдийн тоо: **272 мянга**
Энгийн цэцэрлэгт өдрийн **2,475 төгрөг**, 24 цагийн, сувиллын болон тусгай цэцэрлэгт өдрийн **3,600 төгрөг**.

Цэцэрлэгийн 1 хүүхдэд жилд **807,800-998,200** төгрөгийн санхүүжилт олгодог.





ЭРҮҮЛ МЭНД



Манай салбарын 2020 оны төсөвт “Эрүүл шүд-эрүүл хүүхэд”, “Элэг бүтэн Монгол” зэрэг томоохон хөтөлбөрүүдээс гадна хавдартай тэмцэх үйл ажиллагааг дэмжих зардлуудыг тусгасан байна.



Эмнэлгийн тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэнд
810.2

Эрүүл мэндийн бодлого, удирдлага
184.9

Эрүүл мэндийн даатгал
250.4



НИЙТ ТӨСӨВ
1,245.5
ТЭРБУМ ТӨГРӨГ

▲ 22%
2019 оноос


Урсгал зардал
1,111.7

Хөрөнгө оруулалт
133.8

Эрүүл мэндийн даатгалын сан

ЭМДСангийн нийт төсөв
506.5 тэрбум **24.2%** ▲ **2019 он**

Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх, чанаржуулах чиглэлээр нийт 506.5 тэрбум төгрөг төсөвлөснийг задалж харвал:



Эрүүл мэндийн байгууллагад олгох **359.4**



Рашаан сувилал **29.7**



Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо **23.9**



Эмийн үнийн хөнгөлөлт **53.7**



“Элэг бүтэн Монгол” хөтөлбөр **15.2**



Анхан шатны тусламж үйлчилгээ **15.9**



Магадлан итгэмжлэгдсэн спорт клубүүдэд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгчдэд олгох **2.0**





Үйл ажиллагааны зардал **5.7**




Эрүүл мэндийн салбар дахь Тогтвортой хөгжлийн зорилтыг сайжруулж, төсвийн төлөвлөлттэй уялдуулах бодлогын хүрээнд эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, эх, нялхсын эндэгдлийг бууруулах цогц арга хэмжээнд **343 сая** төгрөгийг төсөвт суулгасан.

Арга хэмжээ

-  Багийн эмч нарыг яаралтай тусламжийн цогц цүнх, эрүүл мэндийн боловсрол, сурталчилгааны материалаар хангах
-  Анхан шат, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийг тэмбүү, ХДХВ, элэгний В, С вирусийн урвалж оношлуур, эрт илрүүлгийн тоног төхөөрөмжөөр хангах
-  Жирэмсэн эх болон хүүхдэд эрт илрүүлэг, хяналтын явуулын үйлчилгээ үзүүлэх
-  Нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр боловсон хүчнийг чадавхжуулах сургалт явуулах
-  Эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн орчин, зохицуулалтуудыг судалж, холбогдох өөрчлөлтийг боловсруулан эхийн эндэгдлийн шалтгааныг бууруулах нөлөөллийн ажлыг судалгаанд суурилан хийх



Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын зорилтот түвшин:



● 2018 оны байдлаар хүрсэн түвшин* ● 2020 он** ● 2025 он** ● 2030 он**

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар магадлан итгэмжлэгдсэн спорт клубүүдэд элсэн орж, хөнгөлөлт авах боломжтой болсон. Даатгалаараа авч болох төрөл бүрийн үйлчилгээнүүдийн талаар мэдээллийг уг холбоосоор авна уу.





Эх сурвалж:


* Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ, Эрүүл мэндийн үзүүлэлт (2018), Улаанбаатар <https://www.chd.mohs.mn/2019/sariin%20medee/2018.pdf>

** Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, (2016) <https://www.legalinfo.mn/annex/details/7105?lawid=11725>

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

Агаарын бохирдлыг бууруулахад зориулан нэмэгдүүлж байгаа хөрөнгийг нийслэлд сайжруулсан түлшний түгээлт, борлуулалтыг зохион байгуулах болон агаарын бохирдлыг бууруулах бусад арга хэмжээнд зарцуулна. Экологийн цагдаа байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэнэ.





Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1,267.0 сая төгрөг

Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөд өртсөн, эвдэрч доройтсон газарт нөхөн сэргээлт хийх, урьдчилан сэргийлэхэд зориулж 1,267.0 сая төгрөг зарцуулна.

АРГА ХЭМЖЭЭ:

Элсний нүүлтийг зогсоох механик хаалт хийх, байгалийн унаган ашигт ургамал тарих

Газар ашиглалтын төвлөрлөөс үүссэн цөлжилт, газрын доройтлыг бууруулах, зам харилцаа, уул уурхай, барилгын ажлын явцад эвдэрч доройтсон газрыг нөхөн сэргээх /арга хэмжээг салбар хоорондын уялдааг ханган хэрэгжүүлэх/

Ойн доройтол бүхий ойт хээрийн бүс, ойгүй тал хээрийн бүсэд байгалийн болон таримал ойгоор ойжуулах, баянбүрдийг нутгийн ургамал, модоор нөхөн сэргээх

Монгол улсын хэмжээнд хөрсний үржил шимийн динамикийн мэдээллийн сан бүрдүүлж, газрын доройтол, цөлжилтийн зураглал гаргах

Иргэд, олон нийт, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цөлжилтийн хор уршгийг таниулах, тэмцэх арга технологийг зааж сургах

3,903.1 сая төгрөг

Гол мөрний урсац бүрэлдэх эх, биологийн олон янз байдал, түүх соёлын үнэт өвийг хамгаалахад онцгой ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, доройтсон орчныг нөхөн сэргээх зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, хамгааллын менежментийг сайжруулахад 3,903.1 сая төгрөг зарцуулна.

АРГА ХЭМЖЭЭ:


Тусгай хамгаалалтад авах 1.9 сая га газар нутагт суурь судалгаа хийх

Улсын тусгай хамгаалалттай 27.9 сая га газарт хамгаалалтын менежментийг сайжруулах

Хамгаалалтын менежментийн хүрээнд авах арга хэмжээ:


- Түймэр, хууль бус мод бэлтгэл, хулгайн ан болон байгалийн нөөцийн зохисгүй ашиглалтаас сэргийлэх арга хэмжээ авах
- Биотехникийн арга хэмжээ авах
- Хамгаалагдаж байгаа биологийн олон янз байдалд мониторинг судалгаа хийх
- Орчны бүсийн айл өрхөд ТХГН-ын ач холбогдол экосистемийн үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн цөлжилтийн үйл явцын хандлага




Эх сурвалж: БОАЖЯ (2019). Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он. Улаанбаатар, 46 дах тал.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын зорилтот түвшин:



Эх сурвалж: УИХ-ын 2016 оны 19-р тогтоолоор батлагдсан Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын зорилтот түвшин:



Монгол улсын нийт нутаг дэвсгэрт тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь

Тусгай хамгаалалтад авсан гол мөрний урсац бүрэлдэх эхийн Монгол улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь


Эх сурвалж:

- БОАЖЯ
- УИХ-ын 2016 оны 19-р тогтоолоор батлагдсан Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д тусгагдсан зорилтот түвшин

* БОАЖЯ 2020 онд 21%-д хүргэх зорилго дэвшүүлсэн

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

2020 онд бидэнд чиглэсэн нийгмийн хамгааллын олон арга хэмжээг авахаар төсөвт тусгажээ.



Нийгмийн хамгааллын салбарын нийт төсөв | **3,445.5** тэрбум ▲ **19.2%** 2019 оноос

Үйл ажиллагааны чиглэлээр

	Нийгмийн даатгал	2,510.7 тэрбум
	Нийгмийн халамж	794.5 тэрбум
	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	118.3 тэрбум
	Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	5.8 тэрбум
	Хөрөнгө оруулалт	16.3 тэрбум

Эдийн засгийн ангиллаар


	Урсгал зардал	3,429.2 тэрбум
	Хөрөнгө оруулалт	16.3 тэрбум

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН


2020 онд нийгмийн халамжийн сангийн зарлага **756.6 тэрбум** төгрөг байна.

	ХАЛАМЖИЙН САН	2020 ОН	2019 ОНООС
	Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	240.0	10% ▲
	Халамжийн тэтгэвэр	117.6	18% ▲
	Цалинтай ээж	110.7	14% ▲
	Асаргааны тэтгэмж	50.2	34% ▲
	Хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг	42.2	
	Халамжийн бусад хөнгөлөлт	31.1	
	Алдарт эхийн тэтгэмж	29.4	
	Амьжиргааг дэмжих тусламж	27.8	
	Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	26.1	
	Насны хишиг	22.3	
	Жирэмсэн эхийн тэтгэмж	18.1	
	Тэтгэвэр, тэтгэмж нэмэгдүүлэх эх үүсвэр	17.5	17% ▼
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмж	12.3	
	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настны тэтгэмж	6.4	
	Үйл ажиллагааны зардал	2.8	
	Олон нийтийн оролцоо түшиглэсэн халамжийн үйлчилгээ	1.8	
	Асрамжийн үйлчилгээ	0.3	50% ▲

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН



Нийгмийн даатгалд хамрагдсанаар хүний амьдралд тохиолдох төрөх, өвдөх, ажилгүй болох, осолд орох зэрэг төрөл бүрийн эрсдэлээс өөрийгөө хамгаалах боломжтой болдог.



Тэтгэврийн даатгалын сангийн орлого	Тэтгэмжийн даатгалын сангийн орлого	ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого	Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	Улсын төсвөөс олгох татаас	ЭМДСангийн шилжүүлэг
1,876.1	167.1	206.7	41.9	399.4	1.1



НИЙГМИЙН ДААТГАЛЫН АППЛИКЕЙШН, ВЭБ САЙТ

<http://www.ndaatgal.mn/v1/view/1219>

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, тэтгэвэр авагчийн мэдээлэл, нэрийн дансны мэдээлэл, тэтгэмжийн зардлын мэдээлэл гэх мэт мэдээллүүдийг авах боломжтой.



АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ

Монгол улсын ард иргэдийн амар амгалан, аюулгүй байдлыг хамгаалж, нийгмийн хэв журмыг сахиулахын төлөө цагдаа, цэрэг, гал сөнөөгч, шүүгч, прокурорын албан хаагчид өдөр бүр хүчин зүтгэдэг билээ.



Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэнэ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулна.

Хар тамхитай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Зэвсэгт хүчний анги, салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна.

Гал унтраах, эрэн хайх, аврах анги, салбар бүлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Нийт төсөв **1,169.7** тэрбум ▲ **9.6%** 2019 оноос



Зэвсэгт хүчин **294.0**



Хил хамгаалах **166.3**



Шүүх, прокурорын байгууллага **113.3**



Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл **321.1**



Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах **102.4**



Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх **116.7**



Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдал удирдлага, судалгаа, шинжилгээ **45.5**





Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх **10.4**

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




Засгийн газрын эдийг засгийн үйл ажиллагаанд хөдөө аж ахуй, газар тариалан, худалдаа, барилга, хот байгуулалт, эрчим хүч, уур уурхай зэрэг салбарын үйл ажиллагаад багтдаг.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшууллыг үргэлжлүүлэн олгоно.



Арьс ширний урамшуулал

11.8 тэрбум ■ 0% (2019 оноос)

Боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан стандартад нийцсэн арьс ширэнд:
Бод малын 1 ш арьсанд **15,000 ₮**
Бог малын 1 ш арьсанд **3,000 ₮**



Мах бэлтгэхэд олгох зээлийн хүүгийн хөнгөлөлт

9.2 тэрбум ▲ 49% (2019 оноос)

20 мянган ТОНН мах бэлтгэнэ.



Ноосны урамшуулал

22.6 тэрбум ■ 0% (2019 оноос)

Боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан ноосонд:

Нарийн, нарийвтар болон **“Малын үржлийн стратеги төлөвлөгөө”**-нд багтсан аймаг, суманд үржүүлж байгаа бүдүүвтэр хонь, тэмээний ноос 1 кг-д **2,000 ₮ төгрөг**, бусад бүс нутагт үржүүлж буй бүдүүвтэр болон бүдүүн хонины ноос 1 кг-д **1,500 ₮**.



Улаан буудайн урамшуулал

23.0 тэрбум ▲ 43% (2019 оноос)

Дотоодын гурилын үйлдвэр, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Улсын нөөцийн салбарт нийлүүлсэн шаардлага хангасан хүнсний улаанбуудайн тонн тутамд олгох урамшуулал

Буудайн стандарт ангилал	Төв болон зүүн бүс	Баруун бүс
I	100,000 ₮	150,000 ₮
II	80,000 ₮	120,000 ₮
III	60,000 ₮	90,000 ₮
IV	55,000 ₮	82,500 ₮



Улсын төсвийн болон гадаад зээл тусламжийн санхүүжилтээр Монгол улсын эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр зам тээвэр, эрчим хүч, хөдөө аж ахуй зэрэг салбарт төрөл бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаагаас заримыг дурдвал.



ЗАМ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР:

- Авто зам **257.8 ТЭРБУМ ₮**
- Гүүрийн байгууламж **24.5 ТЭРБУМ ₮**
- Үер усны хамгаалалт **9.1 ТЭРБУМ ₮**


ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР:

Шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам, нүхэн гарц, бетон гүүр барих зэрэг төслүүд

ЭРЧИМ ХҮЧ


- Цахилгаан **36.3 ТЭРБУМ ₮**
- Дулааны шугам **13.2 ТЭРБУМ ₮**

10 аймгийн төвийн дулааны станц барих, эрчим хүчний төсөл-2 болон 4-р цахилгаан станцын үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг төслүүд





ТӨРИЙН НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ ангилалд Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, орон нутгийн удирдлагын байгууллага, мэргэжлийн хяналт, статистик зэрэг төрийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай байгууллагын зардлууд багтана.



Төсвийн онцлогууд:



СОЁЛ УРЛАГ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

ТӨСВИЙН ОНЦЛОГУУД:



Токио-2020 зуны олимп болон Паралимп-д оролцох шигшээ багийн үйл ажиллагааны зардалыг санхүүжүүлнэ.



Кино үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулах, үндэсний кино контент бүтээх, олон улсын кино наадамд Монгол кино оролцуулах зорилгоор шинэ сан бий болгосон.



“Олон улсын залуучуудын ногоон наадам”-ыг зохион байгуулна.



Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах, үйлчилгээний чанарыг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлнэ.



Урсгал зардал
174.7 тэрбум



Хөрөнгө оруулалт
235.1 тэрбум

НИЙТ ТӨСӨВ
409.8
тэрбум төгрөг

67.1% ▲
2019 оноос



Биеийн тамир
92.6 тэрбум



Соёл урлаг
308.6 тэрбум



Аялал жуулчлал
8.6 тэрбум



Нүүдэлчдийн хосгүй соёл, ёс заншил, унаган төрхөө хадгалан үлдсэн байгальтай үзэсгэлэнт газар нутаг гээд Монголд үзэх зүйл их бий. 2020 оны соёл урлаг, спорт, аялал жуулчлалын салбарын төсөвтэй танилцъя.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2020 онд төсвийн хөрөнгө оруулалтаар нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, орон нутаг болон салбаруудад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн нийгмийн ач холбогдол бүхий төслүүдийг хэрэгжүүлнэ.

НИЙТ

3,806.1 ТЭРБУМ ТӨГРӨГ

ҮҮНЭЭС:

1 **ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

623.4 ТЭРБУМ ТӨГРӨГ

Орон нутгийн төсөвт багтах ба Иргэдийн төлөөлөгчдийн хурал баталж, захиран зарцуулна.

2 **КОНЦЕСС**

323.6 ТЭРБУМ ТӨГРӨГ

“Барих-Шилжүүлэх” концессийн төслийн эргэн төлөлт.

3 **СТРАТЕГИЙН НӨӨЦ БОЛОН БУСАД**

114.1 ТЭРБУМ ТӨГРӨГ

Бусад хөрөнгийн зардалд ашиглана.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

1,828.9 ТЭРБУМ ТӨГРӨГ

нийт 1,427 төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- 110 Цэцэрлэг
- 120 Сургууль
- 71 Эмнэлэг
- 76 Авто зам
- 56 Соёлын төв
- 44 Дотуур байр
- 26 Гүүр
- 13 Спорт цогцолбор

4 **Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж**

Ангилал	Төслийн тоо	2020 онд санхүүжих дүн (тэрбум төгрөг)
Нийслэл	382	584.5
Орон нутаг	1,005	894.1
Улсын хэмжээнд	38	347.7
Элчин сайдын яамд	2	2.6

5 **Гадаад зээл, тусламжаар хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүд**

916.1 ТЭРБУМ ТӨГРӨГ

Улсын төсвийн Хөрөнгө оруулалтын вебсайт
<https://publicinvestment.gov.mn/>



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

АГУУЛГА

01	Засгийн газрын өр болон гадаад зээл, тусламж	40
02	Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратеги	41
03	Засгийн газрын гадаад зээл, тусламж	42
04	Гадаад зээл, тусламж хөгжлийн түнш байгууллагаар	43





Улсын нийт гадаад өр болон Засгийн газрын өр гэж юу болох бас ямар ялгаатай юм бол оо?

Улсын нийт гадаад өр гэдэг нь Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд, Монголбанк, арилжааны банкууд, Засгийн газрын Монгол улсад бүртгэлгүй, оршин суугч бус гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөрийг хэлнэ. Харин Засгийн газрын өр нь төсвөөс зээлдүүлэгчид төлөх гадаад болон дотоод өр төлбөрөөс гадна барих-шилжүүлэх төрлийн концесс, аж ахуйн нэгж байгууллагуудад гаргасан өрийн баталгаанаас бүрдэнэ.



Гадаадын банк, санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулагчдад төлбөрийг төлнө.

Хувийн аж ахуй нэгжүүдийн гадаад өр

Монголбанкны гадаад өр

Арилжааны банкуудын гадаад өр

Засгийн газрын гадаад өр

Засгийн газрын дотоод өр

Өрийн баталгаа

Барих-шилжүүлэх төрлийн концесс



Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллага болон гадаад түнш орнуудад төлбөрийг төлнө.



Улсын нийт гадаад өр



Засгийн газрын өр

*Засгийн газрын гадаад өрөөс гадна Засгийн газрын дотоод үнэт цааснаас гадаадын хөрөнгө оруулагчийн эзэмшиж байгаа болон Засгийн газрын өрийн баталгаа нь Улсын нийт гадаад өрд тооцогддог.

ИРЭХ ОНУУДАД ТӨЛӨГДӨХ АРИЛЖААНЫ НӨХЦӨЛТЭЙ ТОМООХОН ГАДААД ТӨЛБӨРҮҮД:

Гадаад бонд	Дүн (Сая ам доллар)	Купон	Эргэн төлөгдөх огноо
Мазаалай	500	10.875%	2021.04.06
Чингис	1000	5.123%	2022.12.05
Гэрэгэ	800	5.625%	2023.05.01
Хуралдай	600	8.750%	2024.03.09



Монгол улс нь олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудаас урт хугацаатай, хүү багатай нөхцөлтэй зээл түлхүү авдаг учир Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Засгийн газрын өрийн үлдэгдлийг өнөөгийн үнэ цэнээр тооцож дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулан эдийн засагт учрах өрийн дарамтыг тодорхойлдог.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2019-2022 ОНЫ СТРАТЕГИ

ЗОРИЛТ 1.

Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

ЗОРИЛТ 3.

Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.

ЗОРИЛТ 4.

Орчин үеийн технологийн дэвшлийг ашигласан Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэд бүтцийг бүрдүүлнэ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, зах зээлийн нээлттэй, өрсөлдөөнт, хүртээмжтэй байдлыг хангаж, Засгийн газрын үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулна.

ЗОРИЛТ 2.

Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталж, тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна.




Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд хамгийн бага зардлаар санхүүжүүлэхэд чиглэнэ.


ЗОРИЛТ 5.

Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх.


Засгийн газрын нийт өр /тэрбум төгрөг/



Хүүгийн зардлын төсөвт үзүүлэх дарамт буурч байна.



Засгийн газрын өрийн эдийн засагт үзүүлэх дарамт буурч байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ



Монгол Улсын хөгжлийг дэмжих зорилгоор гадаад улс болон олон улсын байгууллагууд Засгийн газарт буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгодог.

Зээл
1,196.3

Нийт зээл,
тусламж
1,346.6
Тэрбум төгрөг

Тусламж
150.3

Нефтийн бүтээгдэхүүн,
эрчим хүчний хангамж,
дэд бүтцийг сайжруулах

Зээл **436.0** Нийт **478.1** Тусламж **42.1**

Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн
үйлчилгээг хүртээмж, чанарыг
сайжруулах

Зээл **180.6** Нийт **205.7** Тусламж **25.1**

Бизнесийн орчныг
сайжруулах, нэмүү өртөг
шингэсэн бүтээгдэхүүн
үйлдвэрлэлийг дэмжих

Зээл **206.9** Нийт **227.6** Тусламж **20.7**


Байгаль орчныг хамгаалах, агаарын
бохирдлыг бууруулах, цэвэрлэх
байгууламж шинэчлэх, аялал
жуулчлал дэмжих

Зээл **218.3** Нийт **252.7** Тусламж **34.4**

Бусад чиглэлийн
төсөл хөтөлбөрүүд

Зээл **154.5** Нийт **182.4** Тусламж **28.0**

МОНГОЛ УЛС



ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ ХӨГЖЛИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГААР

/Тэрбум төгрөг/

	Азийн хөгжлийн банк	Нийт 559.3	40 төсөл 18 төсөл	504.5 54.8
	Хятад	Нийт 206.6	19 төсөл 8 төсөл	168.4 38.2
	Дэлхийн банк	Нийт 189.8	12 төсөл 3 төсөл	175.0 14.9
	Солонгос	Нийт 100.4	10 төсөл	100.4
	Япон	Нийт 97.5	4 төсөл	97.5
	Энэтхэг	Нийт 42.7	2 төсөл	42.7
	Австри	Нийт 32.3	6 төсөл	32.3
	Герман	Нийт 25.4	3 төсөл 4 төсөл	10.2 15.2
	Беларусь	Нийт 18.5	2 төсөл	18.5
	АНУ-ын Мянганы сорилтын корпораци	Нийт 15.0	1 төсөл	15.0
	Европын сэргээн босголт, хөгжлийн банк	Нийт 12.3	4 төсөл 2 төсөл	11.0 1.3
	НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан	Нийт 10.6	1 төсөл	10.6
	Европын хөрөнгө оруулалтын банк	Нийт 10.0	2 төсөл	10.0
	Польш	Нийт 7.6	6 төсөл	7.6
	Кувейт	Нийт 7.6	2 төсөл	7.6
	Франц	Нийт 5.7	2 төсөл	5.7
	Швейцарь	Нийт 1.7	1 төсөл	1.7
	Люксембург	Нийт 1.6	1 төсөл	1.6
	Унгар	Нийт 1.0	1 төсөл	1.0
	Бельги	Нийт 1.0	1 төсөл	1.0



Зээл

Тусламж


НИЙГМИЙН БҮЛЭГТ ЧИГЛЭСЭН ТӨСӨВ

АГУУЛГА

- | | | |
|-----------|--|----|
| 01 | Хүүхдийг төрөөс хэрхэн анхаардаг вэ? | 45 |
| 02 | Ахмад настанд чиглэсэн төсөв | 46 |
| 03 | Төрийн албан хаагч, иргэдийн нийгмийн баталгаа | 48 |
| 04 | Малчдад чиглэсэн бодлогууд | 50 |
| 05 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн төсөв | 51 |
| 06 | Эхчүүдэд чиглэсэн бодлогууд | 52 |



ХҮҮХДИЙГ ТӨРӨӨС ХЭРХЭН АНХААРДАГ ВЭ?



АХМАД НАСТАНД ЧИГЛЭСЭН ТӨСӨВ

Эмээ нь 55 насандаа, харин өвөө нь 60 насандаа тэтгэвэрт гарч ахмад настан болж байлаа. Түүнээс хойш улсаас үзүүлж буй ийм олон төрлийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтүүдийг эдэлж байна даа.

1

Бидэнд

Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр олгоно. НДС-аас өндөр насны тэтгэвэр авах эрх үүсээгүй бол нийгмийн халамжийн сангаас сар бүр **188,000₮** олгоно. Эрүүл мэндийн даатгалыг **төр хариуцна**. Өндөр насны **тэтгэвэр олгоно**.

2

Биднийг асарч буй хүнд

Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд **сар бүр 84,500**

Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэнд **сар бүр 84,500**

3

Бидний тээврийн зардалд

Нийслэл аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.

1000 км-ээс дээш алслагдсан газраас нийслэлд эмчилгээ хийлгэхээр ирсэн тохиолдолд **нэг талын тээврийн зардлыг жилд 1 удаа нөхөн олгоно**.

4

Насны хишгийг жилд 2 удаа олгоно:

65-69 нас: 50,000
70-79 нас: 80,000
80-89 нас: 150,000
90-с дээш нас: 250,000



**Монгол Улсын төрийн шагналт, төрийн соёрхолт, гавьяат, улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага хурлын гишүүн хамаарна.

5

Протез, ортопедийн зардалд

Хөл, гарын протезын хэрэгсэл
5 жил тутам 1 удаа үнэгүй

Сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгслийг худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлыг
5 жил тутамд 1 удаа үнэгүй

Шүдний протезийн хэрэгсэл
3 жил тутамд 1 удаа үнэгүй

7

Бидний амралт, сувилалд

Амралт, сувиллын газар 10 хоног амрахад
200,000 төгрөгийн хөнгөлөлт жилд 1 удаа

Дотоодын рашаан сувиллын зардлын **50%-ийг**, нэг талын тээврийн зардлыг **100% жилд 1 удаа** (Эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр болон хүндэт донор ахмад настанд)

Онцгой гавьяатай болон тусгай эрхт ахмад настанд аймаг нийслэлийн хооронд зорчих, дотоодын рашаан сувилалд явах тохиолдолд **ирэх, буцах замын зардлыг 100% жилд 1 удаа**

6

Бидэнд орон сууцны дэмжлэг болгож

Орон сууцны хөлс төлөх, түлш худалдан авахад
жилд 1 удаа 140,000 төгрөг (тэжээх, тэтгэх хүнгүй, хүндэт донор, алдар цолтой ахмад настнуудад)

Алдар цолтон ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд
жилд 1 удаа 280,000 төгрөг

8

Гавьяаг маань үнэлж

Онцгой гавьяатай ахмад настан*-д
сар бүр 200,000 төгрөг

Тусгай эрхтэй ахмад настан**-д сар бүр
150,000 төгрөг

9

Бусад


Оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, ганц бие **ахмад настан нас барвал 1 сая төгрөг олгоно.**

*Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон, ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр/нөхөр/ хамаарна.




Төрийн албан хаагч, иргэдийн нийгмийн баталгаа

Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулж нэмнэ.



ТӨРИЙН АЛБАНААС ТЭТГЭВЭРТ ГАРАГЧИЙН ТОО

Төрийн албан хаагч тэтгэвэрт гарахад 36 сар хүртэлх цалинтай тэнцэх хэмжээтэй тэтгэмжийг төрөөс олгодог. Ирэх онд 5.7 мянган албан хаагч тэтгэвэрт гарах ба уг тэтгэмжид **127.7 тэрбум** төгрөгийг төсөвлөсөн.



ТЭТГЭМЖ

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй зарим албан хаагчдад тэтгэмж олгодог ба уг зардалд 39.6 тэрбум төгрөг тусгасан.

Харьяа яам	Хүний тоо	Нийт зардал
БХЯ	127	1.0
ЭМЯ	2,247	9.7
ХЗДХЯ	810	11.1
БСШУСЯ	3,752	15.6
ХНХЯ	341	2.3
НИЙТ	7,277	39.6



21 ЖИЛ АЖИЛЛАСАН БАГШ БАТЫН ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЖИШЭЭ

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 57.2.4-т заасны дагуу төрийн үйлчилгээ (ТҮ)-ний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оноос шинээр олгож эхлэхтэй холбоотойгоор **142.7** тэрбум төгрөг төсөвлөсөн.

	2018 он	2019 он	2020 он
ҮНДСЭН ЦАЛИН	683,879	787,701	850,717
МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ	102,582	118,155	127,608
УР ЧАДВАР	102,582	118,155	127,608
АНГИ УДИРДАХ	68,388	78,770	85,072
ЗААХ АРГА	34,194	39,385	42,536
КАБИНЕТ	34,194	39,385	42,536
ОРОН НУТГИЙН НЭМЭГДЭЛ	68,388	78,770	85,072
ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ	0	0	170,143
НИЙТ ЦАЛИН * ХӨЛС	1,094,207	1,260,321	1,531,292

* НДШ болон ХХОАТ суутгаагүй дүн

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа	6-10 жил	11-15 жил	16-20 жил	21-25 жил	26 ба түүнээс дээш
Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь	5%	10%	15%	20%	25%



36 ЖИЛ АЖИЛЛАСАН ҮЙЛЧЛЭГЧ ЧИМГЭЭГИЙН ТЭТГЭВЭРТ ГАРАХ ТЭТГЭМЖИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЖИШЭЭ

